



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 12

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 798 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Луус суманд барьж, ашиглалтад оруулсан нийт 895,391,326 (найман зуун ерэн таван сая гурван зуун ерэн нэгэн мянга гурван зуун хорин зургаа) төгрөгийн өртөгтэй 80 ортой дотуур байрны барилгыг Луус сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөд хавсралтын дагуу бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Луус сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Н.Долгоржав)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2024 оны 5 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 04 дүгээр сарын 22-ний өдрийн
12 тогтоолын хавсралт

Луус сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөд
бүртгэх хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Биет хэмжээ	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Дотуур байрны барилга	м.кв	864		777,108,384
2	Гадна дулаан	м	40	663,343	26,533,720
3	Гадна ус хангамж	м	46	175,172	8,057,912
4	Гадна бохир усны шугам	м	41	147,388	6,042,908
5	Бохир усны септик	ш	1	24,717,312	24,717,312
6	Гадна цахилгаан				28,870,634
	- дэд өртөө	ш	1	20,999,834	
	- Цахилгааны шугам	м	150	52,472	
7	Гадна тохижилт				24,060,456
	Бетон зам талбай, зогсоол	м.кв	378	63,652	
Нийт төсөвт өртөг					895,391,326 (найман зуун ерэн таван сая гурван зуун ерэн нэгэн мянга гурван зуун хорин зургаа) төгрөг